



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 152

Улаанбаатар хот

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц”  
төрийн өмчит хувьцаат компани,  
“Амгалан дулааны станц” хязгаарлагдмал  
хариуцлагатай компанийн 2017 оны эдийн засгийн  
үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин,  
контрактын биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 6 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 2.3, 3.1, 3.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, гүйцэтгэх захирал С.Анхбаяртай байгуулсан контрактын биелэлтийг “Сайн” гэж дүгнэсүгэй.

2.“Амгалан дулааны станц” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, гүйцэтгэх захирал Ш.Баянмөнхтэй байгуулсан контрактын биелэлтийг “Сайн” гэж дүгнэсүгэй.

3.“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал С.Анхбаяртай контрактыг “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын дагуу шинэчлэн байгуулахыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд удирдамж болгосугай

4.“Амгалан дулааны станц” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Ш.Баянмөнхтэй контрактыг шинэчлэн байгуулахыг “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Бямбадоржид даалгасугай.

5.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001723